



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/20/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баруун-Урт сум 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Аудитор: Б.Ганцэцэг Утас: 70512123</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	15
5.1 Төлбөрийн акт.....	15
5.2 Зөвлөмж .....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.08.24 № 46  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,  
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГА Д.ГЭРЭЛБАДРАХ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Ахмад настны хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ зэрэг үйлчилгээнүүд Ehalamj.mn системд шилжсэнээр нийгмийн халамжийн үйлчилгээ 100% цахимд шилжсэн. Мөн "Халамжаар бус хөдөлмөрөөр" уриа дор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг нийгмийн халамжийн үйлчилгээтэй уялдуулж өгснөөр хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг иргэдийн тоо 55 хувиар буурсан.

### Аудитын гол асуудал

Тус байгууллагын үр дүнгийн тайлангаар нийт зардал 680.3 сая төгрөг болж өмнөх оноос 30.3 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор ХХҮГазрын дэргэдэх Ахмадын сувиллыг "Амгалант дэнж" улсын төсөвт үйлдвэрийн газарт шилжүүлсэнтэй холбоотойгоор 2022 онд ахмадын сувиллын нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хураамжийн зардлууд хасагдаж төсөв өмнөх оноос буурч батлагдсантай холбоотой байна.

D:/Bichig hereg/2023/A4 toot

### **Бусад асуудлын хэсэг**

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 2 зорилт, 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 97 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>20,765,925.00</u></b>	<b><u>15,907,487.20</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	20,765,925.00	15,907,487.20
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	95,000.00	95,000.00
35130	Эм боох материал	95,000.00	95,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	20,670,925.00	15,812,487.20
35410	Бичиг хэргийн материал	1,196,752.00	1,108,200.00
35420	Аж ахуйн материал	15,842,551.00	11,702,487.20
35430	Сэлбэг хэрэгсэл	669,500.00	669,500.00
35470	Бусад хангамжийн материал	2,962,122.00	2,332,300.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>534,147,712.26</u></b>	<b><u>496,802,713.77</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	534,147,712.26	496,802,713.77
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	508,022,712.26	474,507,713.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	445,721,546.08	438,961,546.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	-34,856,288.18	-40,417,033.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	184,800,000.00	184,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-181,533,333.28	-183,166,666.60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	199,083,954.61	140,226,230.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-148,557,117.83	-95,543,961.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,104,593.00	70,241,293.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-42,904,312.24	-40,640,863.65
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,165,000.00	1,165,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,001,329.90	-1,117,829.86
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	26,125,000.00	22,294,999.96
39301	Програм хангамж	16,476,900.00	16,476,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-7,081,900.00	-10,911,900.04
39303	Бусад биет бус хөрөнгө	16,730,000.00	16,730,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>554,913,637.26</u></b>	<b><u>512,710,200.97</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>554,913,637.26</u></b>	<b><u>512,710,200.97</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	554,913,637.26	512,710,200.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	393,006,254.41	393,006,254.41
51101	Өмч: - төрийн	393,006,254.41	393,006,254.41
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	159,826,268.77	117,622,832.48
51210	Өмнөх үеийн үр дүн	159,826,268.77	159,826,268.77
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-42,203,436.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,081,114.08	2,081,114.08
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>554,913,637.26</u></b>	<b><u>512,710,200.97</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>849,454,948.00</b>	<b>642,343,285.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>211,688,548.00</b>	<b>4,231,200.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	211,688,548.00	4,231,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	211,688,548.00	4,231,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,248,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	194,440,548.00	4,231,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>637,766,400.00</b>	<b>638,112,085.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	629,316,400.00	614,626,794.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	629,316,400.00	614,626,794.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	8,450,000.00	23,485,291.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,450,000.00	23,485,291.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>710,660,334.86</b>	<b>680,352,591.06</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>710,660,334.86</b>	<b>680,352,591.06</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	682,832,260.99	669,792,704.44
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	478,523,106.67	507,373,711.74
210101	Үндсэн цалин	376,222,277.27	366,780,850.42
210102	Нэмэгдэл	78,796,591.24	88,763,917.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,354,238.16	22,406,884.40
210104	Урамшуулал	150,000.00	16,326,059.09
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	13,096,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	61,137,469.41	62,494,953.18
210201	Тэтгэврийн даатгал	43,264,827.38	43,606,402.51
210202	Тэтгэмжийн даатгал	4,807,911.22	5,116,885.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,816,088.51	4,070,371.83
210204	Ажилгүйдлийн даатгал	840,786.08	869,656.82
210205	Эрүүл мэндийн даатгал	8,407,856.22	8,831,636.98
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	41,287,099.60	24,717,462.25
210301	Гэрэл, цахилгаан	19,147,658.50	2,512,022.25
210302	Түлш, халаалт	18,960,480.00	18,960,480.00
210303	Цэвэр, бохир ус	3,178,961.10	3,244,960.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,081,276.48	19,989,981.01
210401	Бичиг хэрэг	5,180,743.00	5,435,552.00
210402	Тээвэр, шатахуун	3,770,850.00	4,315,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,864,287.48	1,231,133.21
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	685,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,348,494.00	3,054,660.00
210408	Бараа материал акталсны зардал	3,736,902.00	5,267,685.80
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	8,758,437.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	92,400.00	00.00
210502	Хоол, хүнс	8,622,537.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	43,500.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,477,600.00	3,426,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,477,600.00	2,426,500.00
210604	Урсгал засвар	00.00	1,000,000.00

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,956,500.00	3,306,800.00
210702	Дотоод албан томилолт	1,956,500.00	3,306,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	15,817,368.97	4,975,238.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,896,130.97	2,340,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,270,000.00	1,270,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	209,588.00	219,588.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,500.00	59,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,214,500.00	1,003,000.00
210807	Газрын төлбөр	83,650.00	83,650.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	52,793,402.86	43,508,058.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,369,969.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,423,433.86	43,508,058.26
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	27,828,073.87	10,559,886.62
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	830,000.00	4,460,194.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	830,000.00	4,460,194.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	26,998,073.87	6,099,692.62
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,998,073.87	6,099,692.62
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>138,794,613.14</b>	<b>-38,009,306.06</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	285,142,046.93	4,194,130.23
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	285,142,046.93	4,194,130.23
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-285,142,046.93	-4,194,130.23
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-146,347,433.79</b>	<b>-42,203,436.29</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>655,190,400.00</b>	<b>638,112,085.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>17,424,000.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	17,424,000.00	00.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	17,248,000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,248,000.00	00.00
120009	Бусад орлого	176,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>637,766,400.00</b>	<b>638,112,085.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	629,316,400.00	614,626,794.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	629,316,400.00	614,626,794.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	8,450,000.00	23,485,291.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,450,000.00	23,485,291.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>652,794,410.00</b>	<b>631,986,095.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>652,794,410.00</b>	<b>631,986,095.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>624,966,336.13</b>	<b>621,426,208.38</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	478,523,106.67	507,373,711.74
210101	Үндсэн цалин	376,222,277.27	366,780,850.42
210102	Нэмэгдэл	78,796,591.24	88,763,917.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,354,238.16	22,406,884.40

210104	Урамшуулал	150,000.00	16,326,059.09
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	13,096,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>61,137,469.41</b>	<b>62,494,953.18</b>
210201	Тэтгэврийн даатгал	43,264,827.38	43,606,402.51
210202	Тэтгэмжийн даатгал	4,807,911.22	5,116,885.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,816,088.51	4,070,371.83
210204	Ажилгүйдлийн даатгал	840,786.08	869,656.82
210205	Эрүүл мэндийн даатгал	8,407,856.22	8,831,636.98
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>41,287,099.60</b>	<b>24,717,462.25</b>
210301	Гэрэл, цахилгаан	19,147,658.50	2,512,022.25
210302	Түлш, халаалт	18,960,480.00	18,960,480.00
210303	Цэвэр, бохир ус	3,178,961.10	3,244,960.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,982,296.48</b>	<b>15,131,543.21</b>
210401	Бичиг хэрэг	4,876,845.00	5,703,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,770,850.00	4,315,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,864,287.48	1,231,133.21
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	685,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,290,314.00	3,195,660.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>6,520,397.00</b>	<b>00.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	177,400.00	00.00
210502	Хоол, хүнс	6,299,497.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	43,500.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,566,098.00</b>	<b>3,426,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,566,098.00	2,426,500.00
210604	Урсгал засвар	00.00	1,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,956,500.00</b>	<b>3,306,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,956,500.00	3,306,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,993,368.97</b>	<b>4,975,238.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,896,130.97	2,340,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,270,000.00	1,270,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	209,588.00	219,588.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,500.00	59,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,390,500.00	1,003,000.00
210807	Газрын төлбөр	83,650.00	83,650.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>27,828,073.87</b>	<b>10,559,886.62</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>830,000.00</b>	<b>4,460,194.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	830,000.00	4,460,194.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>26,998,073.87</b>	<b>6,099,692.62</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,998,073.87	6,099,692.62
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>2,395,990.00</u></b>	<b><u>6,125,990.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b><u>2,395,990.00</u></b>	<b><u>6,125,990.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b><u>2,395,990.00</u></b>	<b><u>6,125,990.00</u></b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b><u>2,395,990.00</u></b>	<b><u>6,125,990.00</u></b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,395,990.00	6,125,990.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-2,395,990.00</u></b>	<b><u>-6,125,990.00</u></b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	393,006,254.41	2,081,114.08	159,826,268.77	554,913,637.26
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	393,006,254.41	2,081,114.08	159,826,268.77	554,913,637.26
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	393,006,254.41	2,081,114.08	159,826,268.77	554,913,637.26
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-42,203,436.29	-42,203,436.29
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	393,006,254.41	2,081,114.08	117,622,832.48	512,710,200.97

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	646,133,000.00	608,527,101.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	646,133,000.00	608,527,101.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	610,154,600.00	604,066,907.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	494,349,300.00	494,277,711.74
210101	Үндсэн цалин	368,779,300.00	366,780,850.42
210102	Нэмэгдэл	107,181,400.00	88,763,917.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,388,600.00	22,406,884.40
210104	Урамшуулал	00.00	16,326,059.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,568,800.00	60,955,412.18
210201	Тэтгэврийн даатгал	43,092,000.00	42,493,242.51
210202	Тэтгэмжийн даатгал	4,869,200.00	4,999,205.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,895,300.00	3,952,323.83
210204	Ажилгүйдлийн даатгал	973,900.00	864,603.82
210205	Эрүүл мэндийн даатгал	9,738,400.00	8,646,036.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,076,200.00	24,717,462.25
210301	Гэрэл, цахилгаан	2,641,100.00	2,512,022.25
210302	Түлш, халаалт	20,009,000.00	18,960,480.00
210303	Цэвэр, бохир ус	4,426,100.00	3,244,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,945,300.00	10,218,593.21
210401	Бичиг хэрэг	724,600.00	3,634,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,290,700.00	1,472,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,385,600.00	1,231,133.21
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	620,500.00	685,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,923,900.00	3,195,660.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,462,400.00	9,346,490.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,462,400.00	8,346,490.00

210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	140,400.00	120,000.00
210702	Дотоод албан томилолт	140,400.00	120,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,612,200.00	4,431,238.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,200,000.00	2,546,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,270,000.00	1,270,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	270,000.00	219,588.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	59,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	253,000.00
210807	Газрын төлбөр	322,200.00	83,650.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	35978400.00	4460194.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	35,978,400.00	4,460,194.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,506,100.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,472,300.00	4,460,194.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	646,133,000.00	608,527,101.38
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	646,133,000.00	608,527,101.38
131001	Улсын төсвөөс санхүүжих	646,133,000.00	608,527,101.38
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	01.00	01.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	43.00	43.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	32.00	32.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>43.00</b>	<b>43.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	30.00	30.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13.00	13.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>23,485,291.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>23,485,291.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		23,485,291.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		13,096,000.00
210105	Гэрээт ажлын хөлс		13,096,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		1,539,541.00
210201	Тэтгэврийн даатгал		1,113,160.00
210202	Тэтгэмжийн даатгал		117,680.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		118,048.00
210204	Ажилгүйдлийн даатгал		5,053.00
210205	Эрүүл мэндийн даатгал		185,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		4,912,950.00
210401	Бичиг хэрэг		2,069,600.00
210402	Тээвэр, шатахуун		2,843,350.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		3,186,800.00
210702	Дотоод албан томилолт		3,186,800.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	750,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	750,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	23485291.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	23,485,291.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,485,291.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар “Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангах” эрхэм зорилгын хүрээнд "Өрх бүрд ажлын байр" хөтөлбөрийг хэрэгжүүлж, өрхийн орлого нэмэгдүүлэн, ажилгүйдлийн түвшинг бууруулах, мэргэжлийн боловсрол олгох, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтод бүлгийн өрх иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилт тавин нийгмийн халамжийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар” болон УСНББОУС-тай нийцүүлэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2018 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн

A/174 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 42,203.4 мянган төгрөгөөр буюу 7.6 хувиар буурсан байна.

### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	20,765.9	15,907.5	-4,858.4
Үндсэн хөрөнгө	534,147.7	496,802.7	-37,345.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>554,913.6</b>	<b>512,710.2</b>	<b>-42,203.4</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо	554,913.6	512,710.2	-42,203.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө /Өмчийн дүн/</b>	<b>554,913.6</b>	<b>512,710.2</b>	<b>-42,203.4</b>

- Бараа материал данс 4,858.4 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/42 дугаар тушаалаар ашиглалтын хугацаа дууссан, цаашид сэргээн засварлах, ашиглах боломжгүй болсон 133 нэр төрлийн 5,267.7 сая төгрөгийн бараа материалыг акталсан нь нөлөөлжээ.
- Үндсэн хөрөнгө данс 37,345.0 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 5,919.9 мянган төгрөгийн зөөврийн компьютер худалдан авахаас гадна ХХҮЕГ-ын тушаалаар балансаас балансад 4,132.2 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн бол ТӨБЗГ-ийн шийдвэрээр 51 нэр төрлийн 91,838.2 мянган төгрөгийн тавилга, машин тоног төхөөрөмжийг акталж данс бүртгэлээс хассан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 809,193.6 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 646,133.0 мянган төгрөг батлагдсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй цалин хөлс, нэг удаагийн тэтгэмж, бичиг хэргийн зардал, шуудан холбоо, шатахуун зэрэг зардлуудаас хасаж баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 646,133.0 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 614,626.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 608,527.10 мянган төгрөг буюу 94.2 хувьтай зарцуулсан байна.

## Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71902 80101- Үндсэн үйл ажиллагаа (Нийгмийн халамж)	534,455.00	528,853.70	5,601.30	99.00%
2	71902 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг	35,978.40	4,460.20	31518.2	12.40%
3	72102 80101-Үндсэн үйл ажиллагаа (Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих)	75,699.60	75,213.20	486.4	99%
<b>НИЙТ</b>		<b>646,133.00</b>	<b>608,527.10</b>	<b>37,605.90</b>	<b>94.2</b>

Үндсэн үйл ажиллагааны арга хэмжээний зардлын гүйцэтгэл 94.2 хувьтай хэрэгжсэн нь өндөр насны тэтгэвэрт гарах нэг ажилтан өөрийн хүсэлтээр тэтгэвэрт гарахгүй болсон тул тэтгэвэрт гарах нэг удаагийн буцалтгүй тусламжийн санхүүжилт буцаагдсан, мөн мобикомын интернэтийн гэрээний төлбөр төлөхгүй больсон зэрэг нь нөлөөлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Халамжийн сангаас амьжиргааны түвшинг тодорхойлох, дахин судалгааны санхүүжилт 7,000.0 мянга, хяналт шалгалт, маягт хэвлүүлэх зардалд 5,800.0 мянга, амьжиргааг дэмжих зөвлөлийн урамшууллын зардалд 19,662.0 мянга, нийт 32,462.0 мянган төгрөгийн санхүүжилт тус тус авч 23,485.3 мянган төгрөгийн үйл ажиллагааны зарлага гарган 8,976.7 мянган төгрөгийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын халамжийн сангийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтыг авч үзвэл гэрээт ажлын хөлс 13,096.0 мянга, нийгмийн даатгалын шимтгэлд 1,539.5 мянга, хангамж, бараа материалын зардалд 4,912.9 мянга, томилолтын зардалд 3,186.8 мянга, мэдээллийн технологийн зардалд 750.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ганцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 680,352.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,205.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага дэд даргыг үүрэгт ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд дэд дарга, орлогчийн орон тоог хассанаар 6,684.6 мянган төгрөгийн цалинтай холбоотой зардлын хэмнэлтийг бий болгожээ.

Харин Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг мөрдөлгүй зөөврийн 3 компьютер 5,919,9 мянган төгрөгөөр худалдан авсан зөрчил илэрсэн.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8<sup>1</sup> заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд бүрэн гүйцэт мэдээлж байх зөвлөмж өгсөн.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт завсрын аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	0	-			
Зөвлөмж	2	-	2	-	100
Нийт дүн	2	-	2	2	100

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 284.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 284.7 мянган төгрөгийн зөрчил илэрч төлбөрийн акт тогтоож, 3 алдаа илэрснээс, алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Хөдөлмөрийн дотоод журамд заагаагүй чөлөөг цалинтай олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж 284.7 мянган төгрөгийн цалин, хөлс олгосон. Энэ нь Төсвийн төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1<sup>2</sup>, 41 дүгээр зүйлийн 41.2.3<sup>3</sup>, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.6<sup>4</sup> заасныг тус тус зөрчсөнд төлбөрийн акт тогтоолоо.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

<sup>1</sup> бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

<sup>2</sup> төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

<sup>3</sup> төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;

<sup>4</sup> байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох;

Цахим дэлгүүрт байршсан бараанаас төсвийн худалдан авалтыг зохион байгуулаагүй.

Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж төсвийн хөрөнгөөр худалдан авах барааг цахим дэлгүүрээс худалдан авч, эрх зүйн актын хэрэгжилтийг хангах.

**2. Цалин хөлстэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Албан хаагчдад олгож байгаа цалинтай чөлөө нь төсвийг үр ашиггүй зарцуулах эрсдэлийг бий болгосон байна. Тухайлбал 2022 онд давхардсан тоогоор 286 өдрийн цалинтай чөлөө олгосон.

Өгсөн зөвлөмж:

Дотоод журамд заасан цалинтай чөлөө олгож байгаа заалтуудыг Хөдөлмөрийн тухай, Төрийн албаны тухай хууль, ажлын гүйцэтгэл үр дүнтэй уялдуулан дахин шинэчилж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх .

**3. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 88 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж, хөрөнгийг дахин үнэлэх, актлах саналуудыг эрх байгууллагад хүргүүлэх.

**4. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Өмч, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах тушаал шийдвэрийг шилэн дансны цахим системд байршуулаагүй.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т заасан өмч хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг тухай бүр мэдээлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Цахим дэлгүүрт байршсан бараанаас төсвийн худалдан авалтыг зохион байгуулаагүй	1	5,919.9			1	5,919.9			1	5,919.9	1	5,919.9

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 88 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна	1	-			1	-			1	-	1	-
Албан хаагчдад олгож байгаа цалинтай чөлөө нь төсвийг үр ашиггүй зарцуулах эрсдэлийг бий болгосон байна. Тухайлбал 2022 онд давхардсан тоогоор 286 өдрийн цалинтай чөлөө олгосон	1	-			1	-			1	-	1	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>5,919.9</b>			<b>3</b>	<b>5,919.9</b>			<b>3</b>	<b>5,919.9</b>	<b>3</b>	<b>5,919.9</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хөдөлмөрийн дотоод журамд заагаагүй чөлөөг цалинтай олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан	1	284.67	1	284.67								
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>284.67</b>	<b>1</b>	<b>284.67</b>								

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>									
www.shilendans.gov.mn Өмч, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах тушаал шийдвэрийг тухай бүр байршуулаагүй	1	0						1	0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0</b>						<b>1</b>	<b>0</b>